



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 279

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Боловсролын зээлийн сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 48,900,000.00 (дөчин найман сая есөн зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Боловсролын зээлийн сангийн захирал Ж.Ариунболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

132001373

ТӨБЗГ тогтоол-/2021

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дүгээр сарын 27-ны өдрийн
279 дугаар тогтоолын хавсралт

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БУРТГЭЛТЭЙ
ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ, АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГӨ

д/д	Хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтад орсон огноо	Нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Тоо хэмжээ	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилзэр)
1	Хьюндай Sonata-7, 0042 УБҮ, арал-KMHE41BACAB38727	2013-12-25	49,800,000.00	1	5,000,000.00	1
	НИЙТ ДҮН		49,800,000.00		5,000,000.00	
			(дөчин есөн сая найман зуун мянга)		(таван сая)	